



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/03/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)



## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	2
<b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
<b>3. Аудитын тайлан.....</b>	<b>12</b>
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
<b>4. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>17</b>
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Албан шаардлага .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/57  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ  
19020241

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>50,854,965.00</b>	<b>52,963,288.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>50,854,965.00</b>	<b>52,963,288.00</b>
354	Хангамжийн материал	50,854,965.00	52,963,288.00
35410	Бичиг хэргийн материал	6,407,200.00	7,093,100.00
35420	Аж ахуйн материал	30,590,667.00	30,721,090.00
35440	Түлш, шатах тослох материал	580,000.00	150,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,277,098.00	14,999,098.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,221,533,397.44</b>	<b>1,154,603,699.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,221,533,397.44</b>	<b>1,154,603,699.63</b>
392	Биет хөрөнгө	1,192,646,497.44	1,118,470,766.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,066,793,912.00	1,066,793,912.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,564,912.64)	(52,237,284.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,000,000.00	50,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,000,000.00)	(50,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	232,561,761.02	184,221,363.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,809,981.61)	(115,973,517.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,262,376.98	72,460,820.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,085,298.31)	(37,120,288.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	488,640.00	488,640.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(162,879.96)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>28,886,900.00</b>	<b>36,132,933.28</b>
39301	Програм хангамж	911,900.00	911,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(303,966.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	27,975,000.00	35,525,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,272,388,362.44</b>	<b>1,207,566,987.63</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,272,388,362.44</b>	<b>1,207,566,987.63</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,272,388,362.44	1,207,566,987.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337,312,636.93	337,312,636.93
51101	Өмч: - төрийн	337,312,636.93	337,312,636.93
512	Хуримтлагдсан үр дүн	823,666,844.36	760,543,797.55
51210	Өмнөх үеийн үр дүн	823,666,844.36	825,365,172.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(64,821,374.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,408,881.15	109,710,553.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,272,388,362.44</b>	<b>1,207,566,987.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,062,409,816.00	902,430,597.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	204,586,233.00	33,263,743.00
120	Нийтлэг татварын бус орлого	204,586,233.00	33,263,743.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,586,233.00	33,249,743.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,358,000.00	22,954,143.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	84,228,233.00	10,295,600.00
120009	Бусад орлого	-	14,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,823,583.00	869,166,854.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,487,500.00	799,113,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,487,500.00	799,113,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,336,083.00	70,053,254.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	50,549,254.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	26,900,830.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,514,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	13,000,000.00	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	435,253.00	990,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,001,961,610.55	966,119,753.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,001,961,610.55	966,119,753.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,196,579.07	919,894,547.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	627,632,067.52	617,734,787.88
210101	Үндсэн цалин	627,632,067.52	440,613,306.93
210102	Нэмэгдэл	-	154,833,480.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	22,288,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,949,435.00	65,299,866.38
210201	Тэтгэврийн даатгал	54,163,935.00	47,712,901.02
210202	Тэтгэмжийн даатгал	6,372,227.00	4,627,740.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,010,422.00	3,574,511.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,206,172.00	851,429.15
210205	Эрүүл мэндийн даатгал	12,196,679.00	8,533,283.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,786,055.00	75,013,210.00
210301	Гэрэл, цахилгаан	41,748,227.00	44,176,544.00
210302	Түлш, халаалт	27,322,658.00	27,086,400.00
210303	Цэвэр, бохир ус	10,715,170.00	3,750,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,734,932.00	30,671,847.00
210401	Бичиг хэрэг	6,111,460.00	17,263,860.00
210402	Тээвэр, шатахуун	4,286,500.00	4,716,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,514,140.00	3,108,199.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	306,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,492,832.00	5,276,098.00
2105	Нормативт зардал	42,078,420.00	11,315,778.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	457,750.00	1,021,400.00
210502	Хоол, хүнс	41,550,670.00	10,294,378.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	70,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,553,660.00	469,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,041,100.00	469,500.00

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	512,560.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,691,000.00	2,333,000.00
210702	Дотоод албан томилолт	1,691,000.00	2,333,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,812,692.00	39,613,479.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	59,267,942.00	36,329,729.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000.00	35,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	335,500.00	696,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,958,317.55	77,443,079.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,958,317.55	77,443,079.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,765,031.48	46,225,205.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,180,000.00	21,386,012.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,406,012.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,180,000.00	980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,585,031.48	24,839,193.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,585,031.48	24,839,193.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	60,448,205.45	(63,689,156.10)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,132,218.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,132,218.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,132,218.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	60,448,205.45	(64,821,374.81)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	978,181,583.00	892,134,997.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,358,000.00	22,968,143.00
120	Нийтлэг татварын бус орлого	120,358,000.00	22,968,143.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,358,000.00	22,954,143.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,358,000.00	22,954,143.00
120009	Бусад орлого	-	14,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,823,583.00	869,166,854.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	817,487,500.00	799,113,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	817,487,500.00	799,113,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,336,083.00	70,053,254.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	50,549,254.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	26,900,830.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,514,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	13,000,000.00	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	435,253.00	990,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	977,303,683.00	892,134,997.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	977,303,683.00	892,134,997.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,667,459.52	845,909,791.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,367,723.64	587,885,637.81
210101	Үндсэн цалин	463,291,301.24	477,089,142.47
210102	Нэмэгдэл	104,398,381.40	97,809,899.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,678,041.00	12,986,596.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,278,814.27	78,620,666.45
210201	Тэтгэврийн даатгал	67,088,497.44	55,276,295.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,580,858.61	6,081,554.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,244,526.76	4,751,002.83
210204	Ажилгүйдлийн даатгал	304,175.93	1,135,527.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,060,755.53	11,376,286.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,865,477.00	75,013,210.00
210301	Гэрэл, цахилгаан	42,468,881.00	44,176,544.00
210302	Түлш, халаалт	27,322,658.00	27,086,400.00
210303	Цэвэр, бохир ус	7,073,938.00	3,750,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,544,800.00	30,932,747.00
210401	Бичиг хэрэг	9,503,440.00	19,647,760.00
210402	Тээвэр, шатахуун	4,454,500.00	4,134,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,514,140.00	3,260,989.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	306,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,742,720.00	3,583,098.00
2105	Нормативт зардал	44,455,300.00	10,485,478.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	524,350.00	157,500.00
210502	Хоол, хунс	41,081,250.00	10,327,978.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,849,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,999,600.00	2,048,323.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,897,600.00	2,009,323.00
210604	Урсгал засвар	102,000.00	39,000.00
2107	Томиллолт, зочны зардал	1,691,000.00	2,333,000.00
210702	Дотоод албан томилолт	1,691,000.00	2,333,000.00

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,464,744.61	58,590,729.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	91,704,394.61	55,306,979.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	35,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	551,100.00	696,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,636,223.48	46,225,205.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,051,192.00	21,386,012.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,871,192.00	20,406,012.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,180,000.00	980,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,585,031.48	24,839,193.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,585,031.48	24,839,193.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	877,900.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	877,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	877,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	877,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	877,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(877,900.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,419,604,574.14	1,419,604,574.14
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	111,408,881.15	823,666,844.36	1,272,388,362.44
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	111,408,881.15	823,666,844.36	1,272,388,362.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,698,328.00	1,698,328.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,312,636.93	111,408,881.15	825,365,172.36	1,274,086,690.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,698,328.00	00.00	-1,698,328.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-64,821,374.81	-64,821,374.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	760,543,797.55	1,207,566,987.63

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	946,313,600.00	798,352,026.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,313,600.00	798,352,026.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	923,070,000.00	776,966,014.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	596,119,900.00	587,885,637.81
210101	Үндсэн цалин	452,036,200.00	477,089,142.47
210102	Нэмэгдэл	125,730,100.00	97,809,899.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,353,600.00	12,986,596.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,476,200.00	78,620,666.45
210201	Тэтгэврийн даатгал	56,631,400.00	55,276,295.97
210202	Тэтгэмжийн даатгал	5,961,200.00	6,081,554.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,769,000.00	4,751,002.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,192,200.00	1,135,527.38
210205	Эрүүл мэндийн даатгал	11,922,400.00	11,376,286.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,834,500.00	75,013,210.00
210301	Гэрэл, цахилгаан	5,278,000.00	44,176,544.00
210302	Түлш, халаалт	72,538,900.00	27,086,400.00
210303	Цэвэр, бохир ус	8,017,600.00	3,750,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,682,300.00	6,994,447.00
210401	Бичиг хэрэг	1,408,800.00	1,396,560.00
210402	Тээвэр, шатахуун	3,232,900.00	2,029,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,466,900.00	1,460,989.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	306,800.00	306,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,266,900.00	1,800,598.00
2105	Нормативт зардал	56,175,000.00	7,113,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	560,000.00	-
210502	Хоол, хүнс	52,500,000.00	7,113,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,115,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,091,700.00	2,048,323.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,010,100.00	2,009,323.00
210604	Урсгал засвар	81,600.00	39,000.00
2107	Томилолт, зочны зардал	190,400.00	168,000.00
210702	Дотоод албан томилолт	190,400.00	168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,500,000.00	19,121,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	87,360,000.00	15,838,080.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	2,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	630,000.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	360,000.00	35,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	696,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,243,600.00	21,386,012.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,243,600.00	21,386,012.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,261,100.00	20,406,012.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	982,500.00	980,000.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	946,313,600.00	822,067,743.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	799,113,600.00	799,113,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	799,113,600.00	799,113,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	147,200,000.00	22,954,143.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	147,200,000.00	22,954,143.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53.00	53.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	44.00	44.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,622,380.00	68,943,777.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,622,380.00	68,943,777.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,622,380.00	68,943,777.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,220,630.00	23,938,300.00
210401	Бичиг хэрэг	7,949,500.00	18,251,200.00
210402	Тээвэр, шатахуун	450,000.00	2,104,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	562,800.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,258,330.00	1,782,500.00
2105	Нормативт зардал	384,000.00	3,371,578.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	157,500.00
210502	Хоол, хүнс	384,000.00	3,214,078.00
2107	Томилолт, зочны зардал	760,000.00	2,165,000.00
210702	Дотоод албан томилолт	760,000.00	2,165,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	25,257,750.00	39,468,899.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	25,257,750.00	39,468,899.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,336,083.00	70,053,254.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,336,083.00	70,053,254.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс а	-	50,549,254.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагү	-	7,514,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдса	13,000,000.00	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хү	435,253.00	990,000.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны төвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах таслах үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах
- Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон иргэд, байгууллагын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх Хүн ам, гэр бүл, нийгмийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 тушаалаар "Дотоод хяналтын нэгж" байгуулан ажиллах журмыг баталсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Дотоод хяналтын нэгж нь 2021 оны жилийн ажлын төлөвлөгөөнд санхүү төсөв, эд хөрөнгийн ашиглалтын талаар 6 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос 1,5 хувиар буюу 13,536.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,152.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээс 1,5 хувиар буюу 13,536.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,152.3 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас өөрчлөгдөөгүй.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Халамжийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль,

ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

**Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 799,113.6 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 147,200.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 22,954.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 15.6 хувийн биелэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахал гарч ахмадын сувилал, амралтын газрын үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 71,640.2 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 897,095.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд ХХҮЕГ-аас 4,095.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг бүртгэж, тайлагнасан. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 288 ширхэг 65,237.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд ОБГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 150.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 37,798.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 35,561.8 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өглөг, авлагын үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын Төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд үлдэгдэлгүй байна. Бараа материал 69,343.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 955,231.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	50,854.97	52,963.29	(2,108.32)
Үндсэн хөрөнгө	1,221,533.40	1,154,603.70	66,929.70
Нийт хөрөнгө	1,272,388.36	1,207,566.99	64,821.37
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	1,272,388.36	1,207,566.99	64,821.37
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,272,388.36	1,207,566.99	64,821.37

Бараа материалын дансны үлдэгдэл 52,963.29 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,108.32 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн болон бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,154,603.7 мянган төгрөг болж 66,929.7 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор тайлант онд 65,237.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,207,566.9 мянган төгрөг болж 64,821.37 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,164,409.28 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 1,164,409.8 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 218,095.6 мянган төгрөгөөр бууруулан 946,316.6 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь бараа үйлчилгээний бусад зардал хасагдсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 799,113.6 мянган төгрөгийн санхүүжилт, 22,954.1 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, нийт 822,067.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 798,352.0 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 23,715.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 798,352.0 мянган төгрөг буюу 84,3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ХОЛТ ОУБ-аас 25,599.7 мянган төгрөг, өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны санхүүжилт 11,000.0 мянган төгрөг, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааны санхүүжилт 24,379.6 мянган төгрөг, Аймгийн ЗДТГ-аас ахмадын амралтын ажиллагсдын цалин 5,214.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааны номын үнэ 1,722.0 мянган төгрөгийг Хорчин Өлзий ХХК-ийн 5890875641 дугаарын дансанд 12 дугаар сарын 20-нд шилжүүлж, зардал дансанд бүртгэж хаасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Шатах тослох материалын 150.0 мянган төгрөгийн үлдэгдэл, бусад үндсэн хөрөнгийн 488.6 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж тооллогын бүртгэлээр баталгаажуулаагүй байна.

2021 онд улсын төсвөөс 799,113.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулагдаагүй үлдэгдэл 24,839.2 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч МУЗГ-ын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-ийг мөрдөж ажиллаагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн боловч зөрчлийг таслан зогсоогүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилт, бараа материалын үлдэгдлийн зарцуулалтыг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 269,923.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 245,550.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,373.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

4.1.1 Санхүү байдлын тайланд санхүүгийн программын алдаанаас шалтгаалан өмнөх үеийн үр дүн 73,970.3 мянган төгрөгийг зөрүүтэй татагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” заалтын дагуу санхүүгийн тайланд залруулга хийгдсэн.

4.1.2 Мөнгөн хөрөнгийн журналаас түүвэрлэн шалгахад арилжааны банк дахь харилцах дансны орлогын 1,745.0 мянган төгрөгийн орлого зарлагыг бүртгээгүй, 1,900.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг өглөг дансанд бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байдал”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” заалтын дагуу санхүүгийн тайланд залруулга хийгдсэн.

4.1.3 Цалингийн урьдчилгаа, цалингаас суутгасан хуримтлал 166,213.0 мянган төгрөгийг хаахдаа цалингийн өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”; 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 3. “Зардал” болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залруулга хийгдсэн.

4.1.4 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааны номын үнэ 1,722.0 мянган төгрөгийг Хорчин Өлзий ХХК-ийн 5890875641 дугаарын дансанд 12 дугаар сарын 20-нд шилжүүлж, зардал дансанд бүртгэж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" 4.46 дахь заалтыг болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залруулга хийгдсэн.

## 4.2 Албан шаардлага

4.2.1 Түүвэрт сонгогдсон бараа материалын үлдэгдлийг тулган шалгахад Тооллогын комисс нь 150.0 мянган төгрөгийн шатах тослох материалын үлдэгдлийг НХМаягт БМ-8 маягтаар тоолж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл, 20.2.6 дахь заалт, ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.4-ийн 1/ "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 4/ "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.2.3 Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 24,223.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаал "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5 дахь заалтыг болон санхүүгийн тайлангийн "үнэн зөв

байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй зөрчилд өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс			
				Залруулга		Албан шаардлага	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	7	269,923.8	5	245,550.4	2	24,373.4